

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХОЛБОГДОХ
БУСАД БАЙГУУЛЛАГУУДЫН ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН ЕРӨНХИЙ ХҮСНЭГТ

2025 оны 12-р сарын 04Улаанбаатар хот

Ерөнхий мэдээлэл		
1.	Байгууллага, нэгж	Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар, Захиргаа, нэгдсэн удирдлагын хэлтэс
2.	Тайлан боловсруулсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Цэнд-Аюуш
3.	Холбоо барих утас	99078857
Гадаад үйл ажиллагааны тайлан		
Утга		Нийт тоон үзүүлэлт
1.	Гадаад томилолт	-
2.	Зочин төлөөлөгч	БНСУ-ын Грийн эмнэлгийн 18
3.	Албан уулзалт	2
4.	Олон улсын хурал	☒ Цахим 1 удаагийн ☐ Танхим
5.	Сургалт, семинар	☐ Цахим 1 удаагийн ☒ Танхим 2 удаагийн
6.	Гэрээ, Санамж бичиг	БНХАУ-ын Гуандун Бу Ай БНКазУ-ын Олон улсын магадлан итгэмжлэлийн төв (ACQH)
7.	Гадаад арга хэмжээ	-

Жич: Гадаад үйл ажиллагааны ерөнхий мэдээллийг тоон байдлаар хүснэгтэд оруулсны дараа дэлгэрэнгүй тайланг, холбогдох баримт бичгийн хамт хавсаргана.

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

д/д	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
1.ГАДААД ТОМИЛОЛТ							
1.							
2.ЗОЧИН ТӨЛӨӨЛӨГЧ							
2.1.	БНСУ, Сөүл хот	Грийн эмнэлгийн эмч, сувилагч, бусад ажилтан	18	2025 IX/15-IX/19	Чингэлтэй дүүргийн эмзэг бүлгийн хүүхдүүдэд цус багадалтыг илрүүлэх, амны хөндийн эрүүл ахуй, шүдний өвчлөлийг илрүүлэх үзлэг оношилгоо, эмчилгээ хийх	БНСУ-ын Грийн эмнэлгээс эм, эмнэлгийн хэрэгсэл, зочид буудал, өдрийн хоол-50 сая вонн ЧДЗДТГ-аас 11,9 сая ЧНЭ-ээс 2,1 сая	Үзлэгийг Чингэлтэй дүүргийн 39, 72, 145-р сургууль, 16-р хорооны "Тэгш-Өлзий" өрхийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй нэгдсэн эмнэлгийн гуравдугаар амбулаторийн байранд зохион байгуулж нийт 5079 хүүхдийг хамруулсан. Үзлэгт БНСУ-ын Грийн эмнэлгийн 18, ӨЭМТ, Гуравдугаар амбулаторийн хүүхэд, шүд, өрхийн эмч сувилагч, 10 орчуулагч, 10 сайн дурынхан гээд нийт 50 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Үзлэгт 61 нэр төрлийн ханиад, харшил, цус багадалтын эсрэг төмрийн бэлдмэл, амин дэм, сироп, суулгалт гүйлгэлтийн эм, шүдний фторт түрхэлэг, оо сойз, 142 нэр төрлийн эмнэлгийн болон сургалт сурталчилгааны багаж хэрэгсэл ашиглан нийт 5079 хүүхдэд үзлэг оношилгоо хийж, эм үнэ төлбөргүй олгосон.
3.АЛБАН УУЛЗАЛТ							
3.1.	БНСУ, Чонжу хот	Хьюсаранг групп	5	2025	Хамтран ажиллах санал солилцох	-	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас нэг байгууллагыг сонгон хамтран ажиллах, цаашид бүх түвшинд хамтран ажиллах
3.2	Япон улс, Сагамихара	ЧНЭ-ийн захирал, 16 ӨЭМТ-ийн дарга	17	2025 X/05-X/10	УИХ-ын гишүүн Н.Батсүмбэрэлийн санаачлагаар Монгол Японы хамтын ажиллагаа "Эрүүл мэндийн хөгжилд хамтын	-	Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлэг болон 16 өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар Япон улсын Канагава мужийн Сагамихара хотын эрүүл мэндийн байгууллагатай уулзаж, туршлага солилцлоо.

					хүч" ЧД-ийн ӨЭМТ болон Сагамихара хотын эмнэлгүүдтэй хамтын ажиллагааны албан уулзалт	Төлөөлөгчдийг Сагамихара хотын дэд дарга хатагтай Асана Окава болон Яаралтай тусламжийн эмнэлгийн дарга ноён Нараму нар халуун дотноор угтан авч, хотын эрүүл мэндийн тогтолцоо, яаралтай тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтын талаар танилцуулсан. Уг эмнэлэг нь Япон улсад анхны COVID-19 цар тахлын тохиолдлыг бүртгэсэн байгууллага гэдгээрээ онцлог бөгөөд цар тахлын үед яаралтай тусламжийн үйл ажиллагааг амжилттай удирдсан туршлагатай байгууллага юм. Эмнэлэгийн бүтэц, тоног төхөөрөмж, үйлчилгээний менежмент болон эрүүл мэндийн мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцуулсан. Сагамихара хотын Олон нийтийн эрүүл мэндийн төвөөр зочилж, тус төвийн дарга хатагтай Мичи Мимори халуун дотноор угтан авч уулзсан. Тэрээр Япон улсын эрүүл амьдралын хэв маяг, хооллолтын онцлог, мөн япончуудын өвчлөл, нас баралтын түгээмэл шалтгаанууд, тэр дундаа давсны хэрэглээ өндөр байх шалтгаан болон түүнийг бууруулах бодлого, арга хэмжээний талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн. Мөн япончуудын урт наслахад нөлөөлдөг зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт зэрэг туршлагыг хуваалцсан нь төлөөлөгчдөд өндөр ач холбогдолтой байв.
--	--	--	--	--	--	--

							Дараа нь Сагамихара хотын томоохон нэгдсэн эмнэлэг болох Kyodo Hospital-д зочилж, эмчилгээ эрхэлсэн дэд дарга ноён Кимүчи угтан авч тус эмнэлгийн бүтэц зохион байгуулалт, төрөлжсөн тасгуудын үйл ажиллагаа, орчин үеийн тоног төхөөрөмжийн ашиглалт, чанарын удирдлагын тогтолцооны талаар танилцуулж, туршлага солилцсон. Япон улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоог танилцуулсан бөгөөд тус улсад бүх иргэд заавал эрүүл мэндийн даатгалд хамрагддаг, эмчилгээний зардлын 70 хувийг улс, харин 30 хувийг иргэн өөрийн зүгээс төлдөг зохицуулалттай байдаг талаар мэдээлэл өгсөн. Энэхүү албан уулзалтаар Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн байгууллагуудын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэвшилтэт туршлага судлах, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулсан үйл явдал болсон.
--	--	--	--	--	--	--	---

4. СУРГАЛТ, СЕМИНАР ХУРАЛ /ЦАХИМ БА ЦАХИМ БУС/

№	Улс, хот	Албан тушаал	Хүний тоо	Хугацаа	Зорилго	Төсөв	Үр дүн
4.1	БНХАУ, Хөх хот	Харьяа байгууллагуудын хүний нөөц, жендерийн асуудал хариусан ахлах мэргэжилтэн, мэдээллийн технологи цахим эрүүл мэнд хариуцсан ахлах мэргэжилтэн	2	XI/14-XI/21 5 хоног	Эрүүл мэндийн байгууллагын халдваргүйтгэл, ариутгал, мэдээллийн аюулгүй байдал, сувилахуйн тусламж үйлчилгээ, цусны	Олон улсын Монгол эмнэлгийн талаас зардлыг хариуцсан.	Тус сургалтад амжилттай оролцсон.

					төв болон төгсөлтийн дараах сургалтын зохион байгуулалт		
4.2	БНХАУ, Хөх хот	Харьяа байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн /Тасгийн дарга/	1	X/12-XI19 5 хоног	Эрүүл ирээдүйн төлөө эрүүл мэндийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь	Зардлыг Хөх хотын ЭМГ-ээс хариуцсан.	Тус сургалтад амжилттай оролцсон.
4.3	Их Британи	ХДХВ, БЗДХ, сүрьеэ, зонхилон тохиолдох халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	2	X/14-XI17 4 хоног	Global TB clinical	Цахим сургалт	Тус сургалтад амжилттай оролцсон.

5.ГАДААД АРГА ХЭМЖЭЭ

--	--	--	--	--	--	--	--

6. ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

№	Улс, хот	Гадны байгууллагын нэр, албан тушаал	Төрөл	Огноо	Тэргүү	Гарын үсэг зурсан байгууллагын нэр, албан тушаал	Зорилго/Үр дүн
6.1	БНХАУ	Гуандун Бу Ай групп	Санамж бичиг	2025	Хамтран ажиллах тухай	Газрын дарга	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны сургалтад хамруулах, харилцан туршлага солилцох, хамтарсан судалгаа хийх, олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлж оролцох


6.2	БНКазУ	Олон улсын магадлан итгэмжлэлийн төв (ACQH)	Санамж бичиг	2025	Хамтран ажиллах тухай	Газрын дарга	Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн үйл ажиллагааг Олон улсын төвшинд магадлан итгэмжлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх
-----	--------	--	-----------------	------	--------------------------	--------------	---

ТАНИЛЦСАН:

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



У.БАТ-ОЧИР

Б.ЦЭНД-АЮУШ